

ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХ ЯАМНЫ
САЙДЫН ТУШААЛ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1988 оны 2 дугаар
сарын 15 ний өдөр

Дугаар Б/12/40

Улаанбаатар
хот

СУВИЛАГЧИЙН МЭРТЭЖИЛ ОЛГОХ
ТҮР КУРС ХИЙЛГЭХ ТУХАЙ

Улаанбаатар хотын Эрүүлийг хамгаалах газрын харьяа хэс-
гийн эмнэлгүүдэд мэргэжлийн сувилагчид олон тоогоор дутагда-
тай байгааг харгалзан Төлөвлөгөө, эдийн-саясгийн улсын хорооны
зөвшөөрлийг үндэслэн Эрүүлийг хамгаалах яам, Улаанбаатар хо-
тын АДХ-ын Гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. Сувилагчийн мэргэжил олгох 6 сарын курсыг энэ оны 2 ду-
гаар сарын 1-нээс эхлэн сувилагчийн сургууль дээр нээж ажил-
луулахыг Улаанбаатар хотын Эрүүлийг хамгаалах газар /н.Бамбаа/,
Сувилагчийн сургууль /н.Батсүх/-д зөвшөөрсүгэй.

2. Түр курсот хотын эмнэлгүүдэд ажиллаж байгаа ерөнхий бо-
ловсролын сургуулийн 10 дугаар анги төгссөн, Улаанбаатар хотын
иргэний паспорттай, эмнэлгийн ажилд дур сонирхолтой, сахилга
бат, хүмүүжил сайтай, тэргүүний ажиллагаатай ажилчдаас 120 хү-
нийг элсүүлэн суралцуусугай.

3. Энэ арга хэмжээтэй холбогдон гарах 173,0 мянган төгрөг-
ийг Хотын Эрүүлийг хамгаалах оалбарын төсвөөс гаргаж санхүү-
жүүлэхийг хотын Санхүүгийн хэлтэс /н.Гонзор/-т даалгасугай.

ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХ ЯАМНЫ
САЙД Д.Батмандуул
Ч.ЦЭРЭННАДМИД

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙ-
ЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА
С.МАНХУАРТАЛ